

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2022.08.31

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Сумын болон байгууллагын удирдлагуудын хурлыг зохион байгуулж, бодлого шийдвэрийг хүргэн, өвөлжилтийн бэлтгэл ажил, бүтээн байгуулалтын ажлын явцыг хэлэлцэж, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудын чиглэлийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад өгөв.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

Шинээр томилгдон ирсэн хэсгийн төлөөлөгч байгууллагын удирдлагууд, тамгын газрын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах төлөвлөгөөг баталсан.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Аймгийн засаг даргын 05 тоот албан даалгаварын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын онцгой комисс, эрүүл мэндийн төвөөс иргэд, төрийн байгууллагуудад урьдчилан сэргийлэх зөвөлгөө, мэдээлэл хүргэж, нөөцийн бэлэн байдлыг хангах, хүний нөөцийн судалгааг гаргаж, төлөвлөх ажлуудыг гүйцэтгэн, албан тоотын хэрэгжилтийн хариуг хүргүүлсэн.

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, ариутгал, халдваргүйтгэлийг хийж урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, ОНӨААҮГ засвар тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Номын сан фондын номоо цахимд бүртгэлд оруулах ажил хийгдэж, гүйцэтгэл 40 хувьтай байна.

“Нүүдэлчин монгол” соёлын биет бус өвийн фестивалд Онгон сумаа төлөөлж соёлын төвийн 1 ажилтан, 2 ардын авъяастан амжилттай оролцсон.

Засаг даргын тамгын газрын дээвэр засварын ажлыг 19.000.000 төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх, оготно устгалын ажлыг зохион байгуулан хөдөөгийн 1, 3 дугаар багт 100 ширхэг суултуур суулгасан.



Өндөр ашиг шимт үүлдэрийн хээлтүүлэгч авч эрчимжсэн аж ахуйг дэмжих бодлогоор Үзэмчин үүлдэрийн 60 хуц авсан.



Хөдөөгийн 2 багт малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мал угаалгын ажлыг 08 дугаар сарын 18-наас эхлэн зохион байгуулж байна.

Зургаа.Бүтээн байгуулалтын ажлын чиглэлээр:

Цөлжилтийг бууруулах зорилгоор Хавиргын булгийн хөлд “Хиймэл нуур” байгуулах ажлыг эхлүүлсэн.

Сумын төвийн 4, 5 дугаар багт хийгдэх “Жишиг хашаа”-ны ажлыг гүйцэтгэгч талтай гэрээ байгуулж, ажил эхэлсэн.

Гүн өрмийн худаг, ариутгалын Дүк автомашины тендерийг зарласан, шалгаруулалтыг 08 дугаар сарын 30-нд зохион байгуулна.

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ